



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/1672

Хэрлэн сум

Санхүү, эдийн засагчдын өдрийг тэмдэглэж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жил бүр уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлдэг Санхүү, эдийн засагчдын тэмдэглэлт өдрийг тохиолдуулан зохион байгуулах арга хэмжээнд зориулан 4,780,000 (дөрвөн сая долоон зуун наян мянга) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 29-ний өдрийн
А/692 дугаар захирамжийн хавсралт

ШААРДАГДАХ ТООЦОО

д/д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Хоол /ахмад санхүүч/	13	150,000	1,950,000
2	Чуулгын уран бүтээлчдийн хоол	30	62000	1,860,000
3	Баннер	1	250,000	250,000
4	Өргөмжлөл, жааз	10	22,000	220,000
5	Дартс түрээс	1	100,000	100,000
6	Өргөмжлөл	16	25,000	400,000
	Нийт			4,780,000